



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 6/36

Ховд

Б.Ганбаярыг ажилд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 05/13932 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Баттулгын Ганбаярыг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн Цэцэг сумын Засаг даргаар томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Б.Ганбаярыг Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтын дагуу 943539 (есөн зуун дөчин гурван мянга таван зуун гучин ес) төгрөгөөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр олгохыг Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Ариунтуяа)-д зөвшөөрсүгэй.

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг (Б.Ганбаяр-)т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЭЗЭЛСӨЛӨРМЭЭ

8400 01 3043
Zah B/36 Ba

Аймгийн Засаг даргын 2022 оны
11 дүгээр сөрөг 04-ий өдрийн
Б/36 дугаар захирамжийн хэвсгэлт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн
ахлагч:

Г.Одонбаяр (Цэцэг сумын Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Билэгт (Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Б.Онон (Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын Бичиг
хэргийн эрхлэгч)

Нарийн бичиг: Б.Ариунтуяа (Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын
нягтлан бодогч)

-оОо-